



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/310

Мандалговь

Соёл урлагийн мэргэжлийн байгууллагуудын
удирдлагуудад 2022 оны эхний хагас жилийн
үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 40 дүгээр дүгээр зүйлийн 40.4.2, Төрийн албаны тухай 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 07 дугаар хавсралт, 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв Халхын Дуулалт Жүжгийн театр, “Тэнгэрийн тэмдэг” хүүхдийн театр, Музей, Номын сангийн төсвийн шууд захирагч нарын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилт, ажлын үр дүнгийн үнэлгээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн хэрэгжилтийн 2022 оны эхний хагас жилийн урамшууллыг хавсралтад заасан хувиар бодож олгохыг тус байгууллагын нягтлан бодогч (Р.Мөнхсүрэн, Б.Хоролмаа, Ж.Болор-Эрдэнэ, Ө.Рэнцэнханд)- нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111076